



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН
МАН-ЫН ХОРООНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ
ХҮЧЭЭ НЭГТГЭЭ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР
СОНГУУЛЬ-2020

БАЯН-УУЛ

Хүснэгт
Амжилттай
Хүснэгт
Хүснэгт
Хүснэгт

8217144179

АНОА-2020-01/12/2020

Говь-Алтай аймгийн
Баян-Уул сумын МАН-ын хорооны
2020 оны 06 сарын 04 -ны өдрийн
0.1 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН БАЯН-УУЛ СУМЫН МАН-ЫН ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2020-2024/

АГУУЛГА

Уриа: “ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЭ”

НЭГ. Хүний хөгжлийн бодлого

- 1.1 Орлоготой иргэн орон сууцтай өрх
- 1.2 Эрүүл иргэн
- 1.3 Чанартай боловсрол
- 1.4 Гэр бүл, хүүхэд хамгаалал, ахмад настан оюутан залуучуудыг дэмжих бодлого
- 1.5 Өв соёл, спорт

ХОЁР. Эдийн засгийн бодлого

- 2.1 Дэд бүтэц, холбоо мэдээлэл
- 2.2 Хөдөө, аж ахуйг эрчимжүүлэх
- 2.3 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих
- 2.4 Барилга, орон сууцны хөгжил
- 2.5 Төсөл, зээлийн таатай орчинг бий болгох

ГУРАВ. Засаглалын бодлого


- 3.1 Эрх мэдэлтнүүдийг биш эрх зүйт төрийг дээдэлнэ
- 3.2 Түмэнд ойртсон төрийн үйлчилгээ
- 3.3 Авлига, хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал
- 3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах
- 3.5 Гадаад харилцаа хамтын ажиллагаа

ДӨРӨВ. Ногоон хөгжлийн бодлого

- 4.1 Онгон байгалаа хамгаалах
- 4.2 Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх
- 4.3 Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлэх
- 4.4 Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах ногоон байгууламж

ТАВ. Орон нутгийн хөгжлийн бодлого

- 5.1 Жишиг сум хөтөлбөр хэрэгжүүлэх
- 5.2 Нутгийн хөгжил багаас
- 5.3 Баянбогд
- 5.4 Чандмана хайрхан
- 5.5 Баянхайрхан
- 5.6 Хүйсийн говь
- 5.7 Баянговь
- 5.8 Алтангадас



НЭГ: Хүний хөгжлийн бодлого

1.1 Орлоготой иргэн орон сууцтай өрх

1.1.1. “Сумын хөгжил” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, жишиг сум болгох хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.2. Сумдад шинээр хувийн байшин, орон сууц барьж буй иргэдийг ипотекийн зээлд хамруулахад тусална.

1.1.3. Бизнес эрхлэгчдийг төрийн болон орон нутгийн бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

1.1.4. Сумын төвд дэд бүтцийн шийдэл бүхий амины болон нийтийн орон сууц барина. /орлогод нийцсэн, түрээсийн, эко ногоон төслийн/

1.1.5. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуй нэгжүүдийн хоол хүнс, ажлын хувцасыг сумаас хангах зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.1.6. Сумын төвд ажлын байр бий болгох зорилтын хүрээнд жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулж, өрхийн хөгжил бичил бизнесийг дэмжиж, хувийн болон Төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар “Хүний хөгжлийн төв”-ийг байгуулна.

1.1.7 Орлого багатай өрхийн насанд хүрсэн, ажил эрхлээгүй гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.1.8 “Алтайн-Малчин” хөтөлбөрийг төгөлдөржүүлж, малчдын залуу халааг бэлтгэх, уламжлалт мал маллагааны арга барилыг шинжлэх ухаан технологийн хөгжилтэй уялдуулж, мэдлэгтэй малчин бэлтгэх ажлыг МСҮТ-тэй хамтран хэрэгжүүлж, МАА-н нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлж, малчдын орлогыг бодитойгоор нэмэгдүүлнэ.

1.1 Эрүүл иргэн

1.1.7 Сумын иргэдийг эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр хамруулах ажлыг зохион байгуулна.

1.1.8 Эмч мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс сумын эмч, эмнэлгийн ажилтны хүрэлцээ хангамж, ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт арга барил эзэмшүүлж, нэвтрүүлэх зэрэг ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.


1.1.9 Эрүүл мэндийн болон биеийн тамирын мэргэжилтнүүд, багш нарыг урт, богино хугацааны сургалтад хамруулж, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулна.

1.1.10 “Амны хөндий” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг тогтмолжуулна.

1.1.11 Эх хүүхдийн эндэгдлийг гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.1.12 Сумын эмнэлгийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг ээлж дараатай хийж дуусгахын зэрэгцээ орон нутгийн яаралтай тусламжийн чадавхыг дээшлүүлж, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, сумын Эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн 2 автомашинтай болгох замаар хөдөөгийн ард иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулна.

1.1.13 Эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний хэрэглээг хязгаарлаж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулна.



1.2.8 Ахмадуудыг эмнэлгийн үзлэг оношилгоонд хамруулж, эмчилгээ сувилгаанд тогтмол хамруулна.

1.3 Чанартай боловсрол

1.3.1 Боловсрол, соёлын салбарыг чадварлаг боловсон хүчнээр тасралтгүй хангагдах боломжийг бий болгож, удирдах ажилтны ур чадвар, арга барилыг дээшлүүлэх, өндөр мэргэшилтэй багш, соёлын ажилтнуудыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.

1.3.2 Ерөнхий боловсролын сургуулийг байгалийн ухааны лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөрөөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, боловсролын чанар үр өгөөжид анхаарч ажиллана.

1.3.3 Элсэлтийн ерөнхий шалгалт, хөндлөнгийн үнэлгээ, сургалтын чанараас хамаарч, багш, сурагчдыг урамшуулах журмыг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3.4 Математик, англи хэл, орос хэл, хятад хэл, компьютерийн болон бусад хичээлүүдийн сургалтын түвшинг нарийвчлан тогтоож, “Сургалтын чанар” дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, анги дүүргэлтийг аймгийн дундаж хэмжээнд ойртуулна.

1.3.5 Улс, бүс аймгийн төрөлжсөн олимпиадад багшийн ур чадварын болон илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон багш сурагчдын оюуны үнэлэмжийг урамшуулах журам гаргана.

1.3.6 Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.3.7 СӨБоловсролын багш нарыг хөгжүүлэхэд анхааран “Багш хөгжлийн төв”-ийг байгуулж, багш нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулна.

1.3.8 Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

1.4. Гэр бүл, хүүхэд хамгаалал, ахмад настан, залуучуудыг дэмжих бодлого

1.4.1. Хүүхдийн эрх, хөгжил хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд гэр бүлд ээлтэй тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.2. Сумын төвд хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчинг бүрдүүлэн, тэдний чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх орчныг бий болгоно.

1.4.3. Гэр бүлийг дэмжих нийгмийн суурь үйлчилгээний төрөл хэлбэрүүдийг нэмэгдүүлнэ. /Хөршийн холбоо байгуулах/

1.4.4. “Ахмад настны тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор МУ-ын Засгийн газраас 2019 онд батлагдсан “Ахмад настны хөгжил, хамгааллын” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.4.5. Ахмадын өргөөг шинэчлэн засварлана.

1.4.6. Хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.4.7. Өрхийн амьжиргааг дээшлүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4.8. Алтайн ирээдүй болсон залуучуудыг байгаль орчинд хандах эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор хүүхэд залуучуудын хүсэл сонирхлын бүлгийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

8217144139
ДЮА0060 9018301

1.5. Өв соёл, спорт

1.5.1 Сумын соёлын төвийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулан ажиллана.

1.5.2 Сумын соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх, олон нийтийн хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататган, томоохон хэмжээний зан заншил, соёл, өв тээгчдийг урамшуулан баталгаажуулна.

1.5.3 Соёлын төвийн шинэ барилгыг хүлээн авч, орчин үеийн тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хувцас хэрэглэлээр бүрэн хангах ажлыг дэмжин, багуудад урлагийн үйлчилгээг тогтмол хүргэж, хөгжмийн болон бүжгийн хамтлагуудыг бий болгоно.

1.5.4 Номын сангийн номын фондыг баяжуулан, нийтийн уншлагын танхимыг тохижуулна.

1.5.5 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж, сумд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.

1.5.6 Иргэд идэвхтэй хөдлөгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.5.7 Орон нутагт хөгжүүлэх боломжтой зарим нэр төрлийн спортыг бодлогын хэмжээнд дэмжиж, аймаг, улс, бүсийн аваргыг сум орон нутгаас төрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хоёр. Эдийн засгийн бодлого

2.1. Дэд бүтэц, холбоо мэдээлэл

2.1.1 Алтай-Ховд чиглэлийн улсын чанартай автозамаас сумын төв хүртэл 46 км автозам барих.

2.1.2. Сумын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн системтэй болгож, инженерийн шугам сүлжээг шинээр бий болгож, цэвэрлэх байгууламжийг барина.

2.1.3. Төв суурингийн усан хангамжийг сайжруулан, хүн амын ундны усны эрүүл ахуйн стандартыг бүрэн хангуулна.

2.1.4. Сумын төв, шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамж, 0.4 кв/т-ын шугамыг өргөтгөж дэд станц, трансформаторын найдвартай ажиллагааг хангана.


2.1.5. Сумын төвийн засмал замыг үргэлжлүүлэх

2.1.6. Цахилгаан эрчим хүчний салбарын шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлж, цахилгаан хэрэглэгчийн хэрэглээг өдөр , шөнийн тарифт тоолуурт шилжүүлэх замаар хямд цахилгаанаар үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

2.1.7. Алтангадас багт 10кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, дэд станцыг суурилуулна.

2.1.8. Баянбогд баг Шаарын аманд дэд станц трансформатор суурилуулна.

2.1.9. Алтангадас, Баянбогд, Хүйсийн говь, Баянговь багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.



2.1.9. Алтангадас, Баянбогд, Хүйсийн говь, Баянговь багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.2. Хөдөө аж ахуйг эрчимжүүлэх

2.2.1. Мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг тогтмолжуулж, оношилгоо шинжилгээний лабораторийн чадавхийг дээшлүүлж, халдварт празит өвчинтэй тэмцэх ажлыг тогтсон хугацаанд явуулж, галзуу, бруцеллез зэрэг халдварт өвчний тархалтыг бууруулна.

2.2.2. Сум дундын өвс тэжээлийн нөөцийн цэгийг өргөтгөн, багуудад өвс тэжээлийн аюулгүй нөөцийн санг бүрдүүлэн, мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

2.2.3. Жил бүр 2-оос доошгүй инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг шинээр гаргаж, худаг уст цэгийг засварлан сэргээж, бэлчээр усжуулах ажлыг дэс дараатай зохион байгуулна.

2.2.4. Малжуулах хөтөлбөрийг үргэлжлүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой ажиллаж байгаа цөөн малтай залуу малчин өрх, залуу малчдыг эхний ээлжинд хамруулах арга хэмжээг авна.

2.2.5 Мах сүүний чиглэлийн өндөр ашиг шимт мал өсгөх фермийн аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.

2.2.6. Газар тариалан үйлдвэрлэлтийг нэмэгдүүлж, үр бордооны шинэчлэл хийх зорилт тавьж, төмс хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангах бодлого хэрэгжүүлнэ.

2.2.7. Баянговь багт 20 га-д услалтын системийг бий болгож, хадлангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

2.2.8 Жимс жимсгэнэ, чацаргана тариалалтыг эрс нэмэгдүүлж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.2.9 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, өвлийн дулаалгатай хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

2.3 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих


2.3.1 Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх бага оврын үйлдвэр байгуулна.

2.3.2 Тоосгоны болон явган замын хавтангийн үйлдвэр байгуулна.

2.3.3 Оёдлын цех байгуулна.

2.3.4 Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулж, ажлын үр өгөөж, хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.5 Баялаг бүтээгчид, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж иргэд худалдан авагчдийн эрэлт хэрэгцээг хангасан “Баян түншлэл” үзэсгэлэн худалдааг жил бүр орон нутагтаа зохион байгуулж, үндэсний шилдэг үйлдвэрлэгчдийг тодруулж урамшуулан, “Алтай түншлэл” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцуулах дэмжлэг, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана.



2.4.3. Сумын төвд дэд бүтцийн шийдэл бүхий амины болон нийтийн орон сууц барина.

2.4.4. “Жишиг гэр хороолол” төсөл хэрэгжүүлж иргэдийн дунд хуримтлалын бүлэг үүсгэх замаар ая тухтай амьдрах орчинг бий болгоно.

2.5. Төсөл, зээлийн таатай орчинг бий болгох

2.5.1 Ажилгүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд мэргэжил олгох сургалт зохион байгуулж, бүлэг нөхөрлөл, хоршоололд хамруулан ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.5.2 Томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, ажлын байр бий болгоно.

2.5.3 Төсөл хөтөлбөрийн нэгдсэн сан байгуулж, төсөл хөтөлбөрт өрх бүрийг ялгаварлан гадуурхахгүйгээр жигд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.5.4 Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.

2.5.5 Сум орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд тавих хяналтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг иргэдэд тогтмол мэдээлэн, үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Гурав. Засаглалын бодлого

3.1 Эрх мэдэлтнүүдийг биш эрх зүйт төрийг дээдэлнэ

3.1.1 Даргын хууль бус шийдвэрийг биш хуулиа хэрэгжүүлдэг болно.


3.1.2 Төрий албан хаагчдыг сонгуулийн үр дүнгээр намын харьяаллаар хууль бусаар халж, сольж, албан тушаал бууруулж, албан тушаал дэвшүүлж томилдог буруу зуршлыг эцэс болгоно

3.1.3 Иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд зөвшилцлийн зарчмыг тууштай баримталж, цөөнхийг хүндэтгэж, оновчтой санал, санаачилгыг нь дэмжиж ажиллана.

3.2 Түмэнд ойртсон төрийн үйлчилгээ

3.2.1 Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэхийн тулд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

3.2.2 Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй байлгах бүх нөхцөл шаардлагыг сумын түвшинд жигд хэрэгжүүлж ажиллана.



3.2.3 Хөдөөгийн багуудын ажлын нөхцөлийг сайжруулж багийн дарга, эмч нарыг багийн төв дээр тогтмол ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.

3.2.4 Иргэдээ сонсох нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын мөрөөр бодит ажил зохиож, үр дүнг мэдэгдэж хэвшинэ.

3.2.5 Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж, орон нутагт тулгамдаж буй асуудлаар нээлттэй хэлэлцүүлгийг тогтмол явуулж иргэдээс гарсан санал санаачилгыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгаж ажиллана.

3.3 Авлига хүнд суртал, чирэгдэлгүй зөв засаглал

3.3.1 Төрийн нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй иргэд тогтмол танилцаж байх боломжоор хангана.

3.3.2 Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд саад учруулж байгаа элдэв зөвшөөрөл, хязгаарлалтыг багасгаж, нийтийн эрх ашгийг хамгаалсан, зайлшгүй байх заавар, журмуудыг боловсруулж хэрэгжүүлнэ.

3.3.3 Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлдэг болно.

3.3.4 Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагуудын хүнд суртлыг арилган, иргэдэд чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилготой иргэдэд үйлчлэх нэгдсэн төвийг байгуулж ажиллуулна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах

3.4.1 Архидан согтуурах явдал, ахуйн болон малын хулгайтай тууштай тэмцэж, малын хулгайгүй сум болохыг зорино.

3.4.2 Хуулийн байгууллагын албан хаагчдын ёс зүйг сахиулж, хүний эрх, эрх чөлөөг хангана.

3.4.3 Төв суурин газрыг камержуулан гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх орчныг бүрдүүлнэ.

3.4.4 Гэмт хэргийн гаралтыг бууруулах талаар иргэдийн идэвх оролцоог дэмжиж ажиллана.

3.5 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

3.5.1 ОХУ-ын Алтайн хязгаар болон БНЯУ-тай Баян-Уул сумын гадаад харилцааг сэргээнэ.


3.5.2 Гуравдагч орны гадаад харилцааг бий болгох чиглэлээр БНСВУ-тай найрамдалт харилцааг бий болгож, тухайн оронд хэрэгжсэн “Хөдөөгийн хөгжил” төслийг судалж орон нутгийн онцлогт тохирох төсөл боловсруулах.

3.5.3 ОХУ, БНХАУ-д оюутан сургах ажлыг судалж хэрэгжүүлэх.

Дөрөв. Ногоон хөгжлийн бодлого

4.1 Онгон байгалиа хамгаалах

4.1.1 Сумын төвийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг бүрэн шийдвэрлэж, “Ногоон орчин” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.



4.1.2 Байгууллага, аж ахуйн нэгж бүрийг хуулийн дагуу ойжуулах, цэцэрлэгжүүлэх ажилд дайчлан оролцуулах замаар **“Ногоон байгууламж”**, **“Ногоон байгууллага”**, **“Ногоон хашаа”** бий болгоно.

4.1.3 Мод тарьсан иргэдийг урамшуулах журам гарган хэрэгжүүлж, мод үржүүлэн орлого олох боломжийг бүрдүүлнэ.

4.1.4 “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тарьмал ойн талбайг нэмэгдүүлнэ.

4.1.5 Бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх санг хуулийн дагуу бүрдүүлж, байгалийн нөөцийг нэмэгдүүлэх, сэргээх ажлыг эрчимжүүлнэ.

4.1.6 Усны нөөцийн хуримтлалыг бий болгож булаг шандны эхийг хашиж хамгаална.

4.2 Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх

4.2.1 Хадны сүг зураг үзэх, судлах аялал жуулчлалыг хөгжүүлэх

4.2.2 Нүүдэлчдийн ахуйн соёл иргэншлийг үзэх, морин тэмээн аялалыг хөгжүүлэх

4.3 Улс болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг нэмэгдүүлэх.

4.3.1 Аймаг сумын тусгай хамгаалалттай газар нутгийг шинэчлэн баталгаажуулах, ховор амьтан ургамал, түүх соёлын газрын хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авна.

4.3.2 Орон нутаг дахь уул уурхайн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.3.3 Байгаль орчны хуулийн дагуу иргэн бүр мэдээлэгч+хамгаалагч байх тогтолцоог бүрдүүлэн, урамшууллын систем тогтоож хэрэгжүүлнэ.

4.3.4 Ан амьтан тооллогыг орчин үеийн багаж, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл ашиглан хийж, нөөцийн судалгааг шинэчлэн, байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлнэ.


4.3.5 Байгаль хамгаалах зорилгоор нэгдэх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

4.3.6 Хүйсийн говийг улсын тусгай хамгаалалтад авахаар дээд шатны байгууллагад өргөн мэдүүлнэ.

4.4 Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах, ногоон байгууламж

4.4.1 Байгальд ээлтэй амьдрах ухааны хичээл, сургалтыг бүх шатны боловсролын байгууллагатай хамтран хийж, өсвөрийн байгаль хамгаалагчдыг удаан шингэдэг, задардаггүй хог хаягдал, сав баглаа боодлоос татгалзуулах ажлыг зохион байгуулна.

4.4.2 “Хоггүй цэвэрхэн Сум” хөдөлгөөнийг бүх шатанд өрнүүлж, хамтдаа эрүүл цэвэр амьдрах орчныг бүрдүүлнэ.



... үүсгэлтэнд өөрчлөдөг боловч, хур тундасны хэмжээг нэмэгдүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, тоног төхөөрөмжийг шинэчлэнэ.

4.4.5 Үерийн уснаас хөрсний эвдрэлийг хамгаалан, үерийн усыг хуримтлуулан усалгаанд ашиглах хөв, цөөрмийг нэгээс доошгүй улс орны нутгийн төсөв, төсөл-хөтөлбөрийн хөрөнгөөр барьж байгуулна.

ТАВ: Орон нутгийн хөгжлийн бодлого

5.1 Жишиг сум хөтөлбөр хэрэгжүүлэх

5.1.1. “Сумын хөгжил” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, жишиг сум болгох хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.2 Нутгийн хөгжил багаас

5.2.1. Малчдын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих

5.3 Баянбогд баг

5.3.1. Баянбогд баг Шаарын аманд дэд станц трансформатор суурилуулна.

5.3.2. Баянбогд багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.3.3 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх

5.4 Чандмана хайрхан

5.4.1 Намын салаанд хөв байгуулах

5.4.2 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх

5.5 Баянхайрхан

5.5.1 Шандны усны хөлийг тохижуулах

5.5.2 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх

5.6 Хүйсийн говь

5.6.1 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх


5.6.2 Хүйсийн говь багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.7 Баянговь

5.7.1 Баянговь багт 20 га-д услалтын системийг бий болгож, хадлангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

5.7.2 Баянговь багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.7.3 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх



5.8 Алтангадас

5.8.1 Алтангадас багт 10кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татаж, дэд станцыг суурилуулна.

5.8.2 Алтангадас багийн утасны сүлжээг сайжруулах ажлыг бүх нийтийн үүргийн сан, үүрэн холбооны компаниудтай хамтран хэрэгжүүлнэ.

5.8.3 Бэлчээрийн усан хамгамжийг сайжруулан, уст цэгийг нэмэгдүүлэх

БАЯН-УУЛ СУМЫН МАН-ЫН ХОРОО

